



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 1128

Арвайхээр сум

Газар ашиглалтын зориулалтад өөрчлөлт оруулах тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны өрөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 5 дугаар баг, Худалдаа-4 гудамж, 413 тоотод байрлах Чимэдийн Өлзийсайханы (ЙЖ71012219) эзэмшил гэр, орон сууцны хашааны газрын зориулалттай 1851м² газрын зориулалтыг 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц, 13 дугаар баг, Төв цэнгэлдэх-1 гудамж, 101 тоотод байрлах Сүхбаатарын Батмөнх-Эрдэнийн (ЙЮ84102075) эзэмшил 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай 3720м² газрын зориулалтыг 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууцны зориулалттай болгон өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

И.ДОРЖСҮРЭН

6224 11 0448

D:My Doc. Zahiramj. Zasag darga